



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 340,000,000.00 (гурван зуун дөчин сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 автомашиныг "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000255

Төслийн эмчилгээн  
2016 онд  
Уланбаатар хотын  
Доржийн төслийн эмчилгээн

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2019 оны дугаар сарын 20-ны өдрийн  
130 дугаар тоогоолынхавсралт

### БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАЦИН

6098168 + 1118262983

Д/А	Хөрөнгө шилжүүлэн өгөх байгууллага	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Тоёота Ланд Круйзер-200, 01-11 УБҮ, JTMNU01J0K5150548	2018	673	170,000,000.00	"Засгийн газрын автобааз"УТГ
2	Тоёота Ланд Круйзер-200, 00-25 УБЗ JTMNU01J3K4175868	2018	640	170,000,000.00	
НИЙТ ДҮН					340,000,000.00
(гурван зуун дөчин сая)					